

# ТӨСЛИЙН ТОВЧООН

## ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ

2014 оны 10-р сар



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

Хэрэгжүүлэгч:



### БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

#### Төслийн нэр

Нутгийн өөрөө удирдах  
байгууллагын чадавхийг бэхжүүлэх  
нь төсөл

Хэрэгжүүлэх хугацаа:  
2013-2016 он

Төсөв:  
2,850,000 швейцарь франк

Хамрах хүрээ:  
Үндэсний хэмжээнд

#### Зорилтот бүлэг:

- Орон нутгийн бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- Орон нутгийн иргэд
- Нутгийн удирдлага
- Эмэгтэй Төлөөлөгчид
- Нийгмийн эмзэг бүлэг
- Засгийн газар, УИХ, Төрийн байгуулалтын байнгын хороо

### ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

## НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

2012 оны орон нутгийн сонгуулиар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8078 төлөөлөгчдийн 60 гаруй хувь нь шинээр сонгогдсон билээ. Энэ нь Монгол улсын 330 сум, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шинээр болон дахин сонгогдсон Төлөөлөгчдийн орон нутгийн бодлого боловсруулах, хяналт тавих, төсөв батлах сонгуулт үүргээ биелүүлэх чадавхийг бэхжүүлэх сургалтанд хамруулах шаардлагыг бий болгосон юм. Төлөөлөгчдийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулнаар орон нутгийн парламент буюу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) төвлөрлийг сааруулахад аймаг, сумын түвшиндучирч буй бэрхшээлүүдээ шийдвэрлэхдээ нь дэмжлэг болох билээ. Тухайлбал 1) Орон нутгийн хөгжлийн сангаар (ОНХС) санхүүжүүлэх шаардлага, хэрэгцээг тодруулж, оновчтой төлөвлөж, эрэмбэлэх, холбогдох шийдвэрийг гаргах 2) Орон нутгийн нөөцийг илүү үр дүнтэй, тэгш хүртээмжтэй хувиарлахын тулд нутгийн удирдлагын ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах, 3) Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа билээ.



Сүхбаатар дүүргийн ИТХ-аар 2015 оны төсвөө хэлэлцэж байгаа нь

### ҮНДЭСЛЭЛ

1990 оноос Монгол улс ардчилалд шилжих нийгэм, эдийн засаг, улс төрийн өөрчлөлтийг хийж буй билээ. Засгийн газрын төвлөрлийг сааруулах шинэчлэлийн бодлого хэрэгжүүлснээр ардчиллын зорилтуудыг дэмжих буй. Энэхүү шинэчлэлийн нэгэн томоохон арга хэмжээ бол орон нутагт хөрөнгө оруулалт хийх боломжийг бий болгож, ОНХС-г баталсан Төсвийн шинэ хууль юм. Гэвч шилжилт хийж буй бусад хөгжих буй улсуудын нэгэн адил Монгол улс бодлогын шинэчлэл хийхэд томоохон бэрхшээлүүдтэй нүүр тулж байна. Үлэмж хэмжээний байгалийн

нөөц баялаг олборлогдон ашиглагдах болсноос өсөн нэмэгдэж буй эдийн засагт санхүү, төсвийн хяналт хийх чадавхи, туршлага улс орон даяар шаардагдаж байна. Тухайлбал орон нутаг нэлээдгүй хөрөнгө нөөцийг иргэдийн эрх ашгийн төлөө мэдэж зарцуулах эрх мэдэлтэй болсон нөхцөлд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөллийн, бодлого боловсруулж, шийдвэр гаргах, төсөв батлах сонгуулт үүргэг, хариуцлагaa биелүүлэх чадавхийг бэхжүүлэх нь юу юнаас илүү чухлаар тавигдаж байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Монголын төвлөрлийг сааруулах бодлого боловсронгуй болж, нутгийн удирдлагын үйлчилгээ сайжирсан байх

## ҮР НӨЛӨӨ

Үр дүнтэй, хариуцлагатай ил тод нутгийн удирдлагыг бий болгоход нутгийн өөрөө удирдах байгууллага сонгуульт төлөөллийн, бодлого боловсруулах, хянах, төсөв батлах чиг үүргээ хэрэгжүүлэхдэд шаардлагатай чадавхи, арга хэрэгслийг эзэмшсэн байх

### Үр дүн:

**1. Орон нутгийн сонгуульт төлөөлөгчдөд зориулсан үндэсний сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжих арга замыг бий болгосон байх.** Үр дүн 1-ийн хүрээнд аймаг, сум, Улаанбаатар хот, дүүргийн хурлын төлөөлөгчид суурь үүрэг, хариуцлагаа (төлөөллийн, бодлого боловсруулах, хянах, төсөв төсөвлөх) ойлгож, хэрэгжүүлэх чадавхийг олгох сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах. Үндэсний сургалтын хөтөлбөрийг боловсруулахад мэргэжил, арга зүйн тусламж үзүүлж, хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх арга замыг бий болгоно.

**2. Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хөхиүүлэн дэмжих замаар сонгуульт төлөөлөгчдийн хариуцлагыг нэмэгдүүлнэ:** Нутгийн захиргаад дээд шатны захиргааны байгууллага (дээшээ тайлагнах), иргэдийн өмнө (доошоо тайлагнах) хариуцлага хүлээдэг. Орон нутгийн сонгуульт төлөөлөгчдийн хяналтын чиг үүргийг бэхжүүлж, нутгийн удирдлагын үйлчилгээний талаарх ойлголтыг нь нэмэгдүүлэн, улмаар сонгуулиас гадна шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр Төлөөлөгчдийн иргэдийн өмнө хүлээх хариуцлагыг сайжруулах боломжтой юм.

**3. Хурлын хяналтын үүргийг нэмэгдүүлэх үр дүнгийн хүрээнд** хурлын зүгээс хяналт тавих практик арга хэрэгсэл, үлгэрчилсэн заавар журам, маягт, сургалтын гарын авлага зэргийг орон нутгийн нөхцөлд тохиуулан боловсруулж турших замаар ИТХ-ын гишүүдийн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхийг сайжруулахыг зорьж байна. Эдгээр арга хэрэгсэл нь мэдлэг, чадварыг бодит практикт хэрэгжүүлэх хурлын байгууллагын чадавхийг бэхжүүлэхдэд дэмжлэг болох билээ.

**4. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчныг сайжруулах, хурлын хамтын ажиллагаа, туршлага солилцох явцыг дэмжих:** Сонгуульт үүрэг, хариуцлагаа амжилттай хэрэгжүүлж буй сайн туршлагыг тодруулж бусад хурлуудад хүргэх. Мөн сонгуульт үүрэг, хариуцлагаа биелүүлэхдэд хурлуудад учирч буй эрх зүйн орчны бэрхшээлийг тогтоож, өөрчлөн сайжруулахад анхаарч ажиллана.

## ХҮРСЭН ҮР ДҮН

Төлөөлөгчдийг чадавхижуулах сургалт:

Төслөөс 2013-2014 онд 361 хурлын Төлөөлөгчдийн 86 хувийг хамруулан 7 үндсэн сэдвээр сургалт зохион байгуулсан.

Сургалтын сэдэв нь:

1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын Үндсэн хуулийн ба эрх зүйн үндэс
2. Иргэдийн оролцоо, иргэдтэй харилцах
3. ИТХ-ын хуралдааныг зохион байгуулах
4. Орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлага
5. Авлигаас урьдчилан сэргийлэх
6. Байгаль орчин - ногоон хөгжил
7. Хүний эрх ба жендер

Иргэний оролцоог дэмжих нь:

Орон нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх санаачилгыг дэмжих зорилгоор төслөөс тэтгээлт төсөл зарлахад б ИТХ шалгарч сайн туршлагыг бий болгон ажиллаж байна.

Хурлын хяналтын чиг үүрэг нэмэгдэж байна

Мөн 10 ИТХ хяналтын чиг үүргээ нэмэгдүүлэх, тухайлан Орон Нутгийн Хөгжлийн сангийн хэрэгжилтэнд хяналт тавих тэтгэлэг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тэтгээлт төслийг хэрэгжүүлэх явцад бий болж буй сайн туршлага, шинэ санаачилгыг баримтжуулж, бүх шатны ИТХ-ыг нэгтгэсэн интерактив, портал цахим хуудас- [www.khural.mn](http://www.khural.mn) болон бүсийн туршлага солилцох уулзалтуудаар бусад хурлуудад түгээн ажиллаж байна.

Эрх зүй, бодлогын түвшинд оруулж буй хувь нэмэр

Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчинд хийх өөрчлөлт, холбогдох хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх саналыг ИТХ, төлөөлөгчдөөс цуглувуулж УИХ-ын Териийн байгуулалтын байнгын хороогоор дамжуулан холбогдох ажлын хэсгүүдэд хүргүүлсэн. Бүх шатны 361 ИТХ-ын холбосон [www.khral.mn](http://www.khural.mn) интерактив цахим хуудсыг бүтээж хөгжүүлсэн ба одоогоор 21 аймаг, 9 дүүрэг өөрсдийн дэд цахим хуудсаа хөгжүүлж өдөр бүр 15-29 хүртэлх шинэ мэдээ, мэдээлэл нийтэлж байна. Энэхүү цахим хуудас нь сайн туршлага, санаачилгаа хувваалцах, мэдлэг, мэдээлэл солилцох өргөн боломжийг хурал, Төлөөлөгчдөд олгож байгаа билээ.

## Хамтран хэрэгжүүлэх түншүүд:

- Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
- Удирдлагын Академи

## Холбоо барих:

### НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Засгийн газрын 11-р байр, 606 тоот

Утас: (+976 51) 264565

Факс: (+976 51) 264565

И-мэйл: [cslg@parliament.mn](mailto:cslg@parliament.mn)

Вэб хуудас: [www.khral.mn](http://www.khural.mn)

## Монгол дахь

### Швейцарийн ЭСЯ-НЫ

### Хамтын ажиллагааны газар

Скай плаза бизнес төв,

Олимпийн гудамж 12,

Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо

Улаанбаатар хот

Ш/Х 37, Улаанбаатар 14253,

Монгол улс

Утас: +976 11 331 422

Факс: +976 11 331 420

И-мэйл: [ulaanbaatar@eda.admin.ch](mailto:ulaanbaatar@eda.admin.ch)

Вэб: [www.swiss-cooperation.admin.ch/mongolia](http://www.swiss-cooperation.admin.ch/mongolia)